



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Цас цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт их хэмжээний цас орж, шууран 1, 2 дугаар хорооны гэр хорооллын гудамж талбай цасанд боогдон битүүрсэнтэй холбогдуулан тусгай зориулалтын автомашин, тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Тус ажилд Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-уудын машин механизмыг татан оролцуулж, цас цэвэрлэгээний ажлыг чанартай зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.


3. Тус ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, зарцуулагдах 2,502,500 (Хоёр сая таван зуун хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Зохион байгуулсан ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэд, олон нийтэд сурталчлахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т, дээрх арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш 7 хоногийн дотор тайланг ирүүлж, үр дүнг танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 01 сарын 17-ны өдрийн 105 дугаар
захирамжийн хавсралт



ЦАС ЦЭВЭРЛЭГЭЭНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Байгууллагын нэр	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Илч-Орд НӨААТҮГ	Шатахуун (дизель)	л	260	3850	1,001,000
2	Багахангай тохижилт ОНӨААТҮГ	Шатахуун (дизель)	л	260	3850	1,001,000
3	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ	Шатахуун (дизель)	л	130	3850	500,500
Нийт дүн						2,502,500